

# 2024 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан



**Flexibusiness**  
100 сая ₮<sub>жүртэл</sub>  
3.80% → 3.31%

 ЭРХ ТООЦООЛОХ





# Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2024 оны III улирлын  
санхүү, үйл ажиллагааны тайлан

01

Бизнесийн үйл  
ажиллагаа

02

Санхүүгийн  
тайлагнал

03

Компанийн  
засаглал



БИЗНЕСЭЭ  
ХАМТДАА  
АСААЯ

**Х.Болорцэцэг**

"Уран ган санаа" ХХК-ийн захирал



## 2024 ОНЫ III УЛИРЛЫН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

### Салбарын тойм

Санхүүгийн Зохицуулах Хорооноос мэдээлснээр 2024 оны 2-р улирлын байдлаар нийт 549 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Салбарын нийт зээлийн багц 4.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.7% буюу 1.5 тэрбум төгрөгөөр өсжээ.

Үүнээс 90.8%-ийг хэвийн зээл, 3.0%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 6.2% -ийг чанаргүй зээл эзэлж байна. Түүнчлэн, олгосон зээлийн 67.9%, төлөгдсөн зээлийн 69.3%-ийг хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлж байна.

### ЛэндМН-ийн үйл ажиллагаа

“ЛэндМН ББСБ” ХК нь 2016 онд Монголд анх удаа барьцаагүй финтек зээлийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлснээс хойш өдгөөг хүртэлх 8 жилийн хугацаанд нийт 1.3 сая гаруй хэрэглэгчтэй болон өргөжөөд байна. Энэ хугацаанд бид харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэн, хамгийн сүүлийн үеийн технологийн шийдэлд тулгуурласан Хэрэглээний болон Бизнесийн зээлийн үйлчилгээг үзүүлж байна.

2024 оны 3-р улиралд бид LendMN аппликейшнээ шинэчилснээр харилцагчийн нууцлал аюулгүй байдлыг сайжруулан, илүү олон боломжуудыг багтаасан финтек зээлийн үйлчилгээг LendMN 2.0 аппликейшнээр үзүүлж эхэллээ. Энэхүү өөрчлөлтөөр:


- ✓ Харилцагч бүртгэхэд илүү хялбар болов;
- ✓ Нийгмийн даатгалын мэдээлэлд үндэслэн зээлийн эрх тооцоолдог болов;
- ✓ Бүх төрлийн лавлагаа, тодорхойлолтыг аппликейшнээс авдаг болов;

Нийт ББСБ-уудаас 55 нь Финтек зээлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд үүний 48 нь технологи, уламжлалт зээлийн үйлчилгээг хослуулан хүргэж, 7 нь зөвхөн технологи дээр суурилсан зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны судалгаанд зөвхөн технологи ашиглан гар утасны аппликейшнээр зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа ББСБ-уудыг уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудтай харьцуулахад олгосон болон төлөгдсөн зээлийн эргэлт сайн байгааг дурджээ.

✓ Харилцагчдын мэдээллийг хамгаалах болон бусад функцүүдийг илүү сайжрууллаа.

Түүнчлэн “Plus” хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээ харилцагч нарынхаа хэрэгцээнд тулгуурлан уян хатан нөхцөлтэйгөөр шинэчиллээ. Ингэснээр бид харилцагч нарынхаа санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, өөртөө хөрөнгө оруулалтын зөв дадлыг бий болгоход ихээхэн хувь нэмэр үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.



### LendMN-тэй Бизнесээ хамтдаа асааж буй харилцагчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр ...

LendMN аппликейшн нь хиймэл оюун ухааны технологид тулгуурлан бичил, жижиг дунд бизнес эрхлэгч болон хувиараа бизнес эрхлэгч нарын орлогыг дансны хуулгаар баталгаажуулан, харилцагчийн зээлжих чадварыг үнэлснээр барьцаагүй, бүрэн дижитал зээлийг 2 минутад авах боломж бүхий Flexi Business зээлийн үйлчилгээгээ нэвтрүүлсэн. Ингэснээр бид бичил, жижиг бизнесүүдэд илүү хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг бодитоор хүргэж байна.



2024 оны 3-р сард LendMN аппликейшнд Flexi Business зээл олгогдож эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар нийт 58 мянга гаруй харилцагчийн зээлийн хүсэлтийг хүлээн авч, зээлжих чадварын үнэлгээг хийсэн бөгөөд уг бизнесийн зээл нь нийт зээлийн багцын 20 гаруй хувийг бүрдүүлж байна.

Flexi Business зээлийг авснаар бизнесээ өргөжүүлсэн харилцагч нарын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж, талархсан сэтгэгдэл тасралтгүй ирсээр байгаа нь бидний бүтээгдэхүүн үйлчилгээ харилцагч нарын маань хэрэгцээнд нийцээд зогсохгүй тэдний санал зөвлөмжөөр улам бүр сайжирсаар байгаад баяртай байна.



## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд /сүүлийн 3 улирал тус бүрээр/:



## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /эссэн дүнгээр, тэрбум төгрөг/	2022 III	2023 III	2024 III
<b>Нийт орлого</b>	<b>13.0</b>	<b>33.2</b>	<b>64.1</b>
Хүүгийн зардал	(3.0)	(6.8)	(14.9)
<b>Цэвэр орлого</b>	<b>10.0</b>	<b>26.4</b>	<b>49.2</b>
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(2.0)	(3.1)	(3.4)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(1.2)	(2.3)	(3.5)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>6.8</b>	<b>21.0</b>	<b>42.3</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(3.4)	(4.5)	(6.3)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>3.4</b>	<b>16.5</b>	<b>36.0</b>
Татварын зардал	(0.4)	(3.5)	(8.5)
<b>Цэвэр ашиг</b>	<b>3.0</b>	<b>13.0</b>	<b>27.5</b>

## Санхүү байдлын хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2022 III	2023 III	2024 III
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	2.3	4.8	16.2
Зээлийн багц (цэвэр)	46.3	94.7	200.8
Бусад хөрөнгө	2.3	3.3	9.5
Үндсэн хөрөнгө	0.7	0.7	1.3
Биет бус хөрөнгө	0.4	0.4	0.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>52.0</b>	<b>103.9</b>	<b>228.2</b>
<b>Өр төлбөр болон эздийн өмч /1-9 сар, тэрбум төгрөг/</b>			
<b>Өр төлбөр</b>	<b>30.3</b>	<b>68.1</b>	<b>163.9</b>
Эх үүсвэр	24.6	57.4	140.8
Бусад өглөг	2.9	7.9	20.3
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>21.7</b>	<b>35.9</b>	<b>64.3</b>
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	13.2	27.4	55.8
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>52.0</b>	<b>103.9</b>	<b>228.2</b>

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) нь 2024 оны III улиралд 1 удаа ээлжит хурал, 1 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 7 тогтоол гаргаж, 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгож, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн хүрээнд компанид мөрдөгдөх бодлогуудыг шинэчлэн батлах болон Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгохтой холбоотой асуудлуудыг шийдвэрлэн ажилласан байна.

ЛэндМН нь ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлсэн болно.

### “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ЛэндМН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн үнэлгээний хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 93%-тай хэрэгжүүлэн ажиллаж, компанийн засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2024 оны эхний хагас жилийн байдлаарх “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын Компанийн засаглалын кодексын үнэлгээний тайлан”-г гаргасан ба ЛэндМН нь тус тайланд Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП-20 Аж ахуй нэгжийн жагсаалтад багтсан байна.



**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)

2024 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн:  
Маркетингийн хэлтсийн менежер Б.Батбилэг  
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр